



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 433

Мандалговь

Г Зардал гаргах тухай Г

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.8, 5.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээг утган хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбай, нэрэмжит төгөл, улсын чанартай авто зам дагуу тарьсан мод, сөөгөнд нөхөн тарилт хийх, “Дундговио ногооруулъя” ажлын хэсгийн гишүүд Өмнөговь аймгийн Агропаркд туршлага судлахад шаардагдах зардлыг тус тус хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 42,725,400 (Дөчин хоёр сая долоон зуун хорин таван мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Дундговио ногооруулъя” төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Л.Доржбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822111080